

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙГ УРСГАЛ ЗАРДЛЫН ШИНЖТЭЙ, НЭГ УДААГИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛД ХЭТ ИХЭЭР ТӨЛӨВЛӨЖ, ЗАРЦУУЛЖ БАЙГАА НЬ ТУС САНГИЙН ХӨРӨНГИЙН ҮР НӨЛӨӨГ БУУРУУЛЖ, МӨН ЧАНАРЫГ АЛДАГДУУЛЖ БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН 2024 ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

АУДИТЫН КОД: ЗАА-2025/31-12-ШТА-ГА



Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа
Утас: 7046-3612, Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn
Аудитын менежер Х.Болдбаатар
Утас: 7046-3783, Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn
Ахлах аудитор Ц.Оюунсүвд
Утас: 99076038, Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn
Аудитор Г.Баасанжаргал
Утас: 99032514, Цахим хаяг: baasanjargalg@audit.gov.mn
Аудитор О.Алтансүвд
Утас: 88009224, Цахим хаяг: altansuvdo@audit.gov.mn
Аудитор П.Номинзул
Утас: 90819696, Цахим хаяг: nominzulp@audit.gov.mn

Улиастай хот

2025 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
www.open.audit.mn хаягаас үзнэ үү

АГУУЛГА

Тушаал	2
Товчилсон үгийн тайлбар.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, аудитын шалгуур үзүүлэлтийн талаарх мэдээлэл.....	4-5

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬД ЗААСАН ЭХ ҮҮСВЭР ТУС БҮРЭЭР БҮРДҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН Ч ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГААС ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛГИЙГ БАТАЛСАН ХУВААРИЙН ДАГУУ БҮРЭН ОЛГООГҮЙ БАЙНА.

1.1 Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасан эх үүсвэр тус бүрээр төлөвлөж, бүрдүүлж хуваарилсан байна..... 6-9

1.2 Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хуульд заасан шаардлага, шалгуур хангаагүй зарим төсөл арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.....9-12

БҮЛЭГ 2. ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙГ УРСГАЛ ЗАРДЛЫН ШИНЖТЭЙ, НЭГ УДААГИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛД ХЭТ ИХЭЭР ТӨЛӨВЛӨЖ, ЗАРЦУУЛЖ БАЙГАА НЬ ТУС САНГИЙН ХӨРӨНГИЙН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨГ БУУРУУЛЖ, МӨН ЧАНАРЫГ АЛДАГДУУЛЖ БАЙНА.

2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний 55.6 хувьд шууд худалдан авалт хийсэн нь сангийн хөрөнгийг хэт жижиглэж, журамд нийцээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж санхүүжүүлсэн холбоотой байна.....12-15

2.2 ОНХС-ийн хөрөнгийг урсгал зардлын шинжтэй, нэг удаагийн арга хэмжээний зардалд хэт ихээр төлөвлөж, зарцуулж байгаа нь тус сангийн хөрөнгийн үр нөлөөг бууруулж, мөн чанарыг алдагдуулж байна.....15-17

2.3 ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байна.....17-18

БҮЛЭГ 3. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНД АЙМАГ, СУМДЫН ИТХ, ЗДТГ ХЯНАЛТ ТАВЬЖ, ТАЙЛАГНАХ ҮҮРГЭЭ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 39.6 хувьд сумдын ИТХ хяналт хэрэгжүүлээгүй байна.....18-20

3.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн тайланг, журмын дагуу Сангийн яаманд хүргүүлсэн байна.....20-21

ДҮГНЭЛТ 22

ЗӨВЛӨМЖ23

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ТАЙЛБАР24



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 1/25

Улиастай

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, 18.10 дахь хэсэг, 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1.4, 2.13 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг тогтоосон хугацаанд ирүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөсүгэй.

3. Аудитын тайланг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлэхийг аудитын баг (ахлах аудитор Ц.Оюунсүвд)-д, нээлттэй аудит цахим хуудсаар нийтэд мэдээлэхийг аудитор (Г.Нармандах)-д үүрэг болгосугай.

4. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор Ц.Оюунсүвд)-д даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Х.Болдбаатар)-т үүрэг болгосугай.

Д.БАТ-УНДРАА



D/Албан бичиг/Тушаал-А/2025

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТТХ	Төсвийн тухай хууль
АОНХС	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНАХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
СХДАА	Санхүүгийн хяналт дотоод аудитын алба
ТАХ	Төсөл арга хэмжээ
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/108 тушаалаар баталсан "Аудитын жилийн төлөвлөгөө", Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын "2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г үндэслэн гүйцэтгэв.
Аудитын зорилт	"Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө"-т байдалд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, аудитын тайланг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх; - Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх; - Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Тус аудитад аймаг, сумын ИТХ, ЗДТГ, СТСХ, ХОХБТХ, аймаг сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой үйл ажиллагааг хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудит стандартын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг үндэслэн тулган баталгаажуулалт хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлэн, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулан, зөвлөмж бэлтгэлээ. Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд: ✓ Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт; ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль; ✓ Төсвийн тухай хууль; ✓ Тарийн хэмнэлтийн тухай хууль; ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль; ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль; ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль; ✓ Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан

**Аудитын багийн
бүрэлдэхүүн,
хугацаа**

- "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам";
- ✓ Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан "Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал";
 - ✓ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам";
 - ✓ Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам";
 - ✓ Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа хянан удирдаж, аудитын менежер Х.Болдбаатар үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитор Г.Баасанжаргал, О.Алтансүвд, П.Номинзул нар аудитыг гүйцэтгэлээ.

Аудитыг 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс эхлүүлж, хөтөлбөрт заасан хугацаанд холбогдох үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын тайланг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт нэгтгүүлж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүллээ.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Орон нутгийн хөгжлийн сангийн (цаашид ОНХС гэх) зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бус нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгддэг.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС болон улсын төсвөөс аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг Завхан аймагт 14,040.3 сая төгрөгөөр баталсныг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн "Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай" хуулиар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого өссөнтэй уялдуулан 660.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн орлогын шилжүүлгийг 14,700.7 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 14,095.3 сая төгрөгийг олгожээ.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2, 60.2.41, 60.2.82-д заасны дагуу аймаг, сумдын ИТХ-аар ОНХС-д олгох орлогын шилжүүлгээс гадна 6,061.6 сая төгрөгийн эх үүсвэрийг нэмж баталсан байна.

Аймгийн хэмжээнд 2024 онд ОНХС-ийн эхний үлдэгдэл 2,751.0 сая төгрөг, сангийн орлогын эх үүсвэрийг нийт 20,762.3 сая төгрөгөөр төлөвлөснөөс 18,663.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, гүйцэтгэлээр 18,735.9 сая төгрөгийг зарцуулж, жилийн эцэст 2,675.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬД ЗААСАН ЭХ ҮҮСВЭР ТУС БҮРЭЭР БҮРДҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН Ч ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГААС ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛГИЙГ БАТАЛСАН ХУВААРИЙН ДАГУУ БҮРЭН ОЛГООГҮЙ БАЙНА.


1.1 Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасан эх үүсвэр тус бүрээр төлөвлөж, бүрдүүлж хуваарилсан байна.

1.1.1 Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлсэн байна.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлд ОНХНС болон улсын төсвөөс Завхан аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг анх 14,040.3 сая төгрөгөөр баталсан бөгөөд 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр 660.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, нийт 14,700.7 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-д заасны дагуу орлогын эх үүсвэрийг ОНХНС болон улсын төсвөөс олгосон орлогын шилжүүлгээс 13,824.2 сая төгрөг, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрөөс 82.2 сая төгрөг, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрөөс 231.9 сая төгрөг, жилийн гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал 562.4 сая төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөжээ.

График-1



1.1.2. ОНХНС-аас АОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлал”-аар тооцож хуваарилсан ч 605.4 сая төгрөгийг дутуу олгосон байна.

ОНХНС-аас аймгийн ОНХС-д 14,700.7 сая төгрөгийг олгохоор төлөвлөсөн ч гүйцэтгэлээр 14,095.3 сая төгрөгийг олгож, 605.4 сая төгрөгийг дутуу олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу хуваарилагдсан олгох орлогын шилжүүлгийг аймгийн ИТХ-ын 2023 оны

94 дүгээр тогтоолоор аймгийн ОНХС-д 5,265.5 сая төгрөг, сумдын ОНХС-д 8,774.8 сая төгрөг, нийт 14,040.3 сая төгрөгийг олгохоор анх баталсныг аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр тогтоолоор аймгийн ОНХС-д 5,925.9 сая төгрөг, сумдын ОНХС-д 8,774.8 сая төгрөг, нийт 14,700.7 сая төгрөг олгохоор тодотгож, гүйцэтгэлээр аймгийн ОНХС-д 5,649.0 сая төгрөг, сумдын ОНХС-д 8,446.3 сая төгрөг, нийт 14,095.3 сая төгрөгийг олгосон байна.

ОНХС-ийн санхүүжилтийг дутуу олгож, ихэнх хувийг оны эцэст санхүүжүүлж байгаа нь төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байх, улирлын шинж чанартай төсөл, арга хэмжээ он дамжих, огт хэрэгжихгүй байх эрсдэлийг дагуулж байна.

1.1.3. Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 328.5 сая төгрөгөөр дутуу олгосон байна.

Сангийн яамнаас 605.4 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсоноос шалтгаалан сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг төлөвлөснөөс 328.5 сая төгрөгийг бууруулан олгосон явдал юм.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.3¹-т заасны дагуу ОНХС-ийн 2023 оны төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээгээр Идэр, Нөмрөг, Отгон, Сантмаргаз, Тэлмэн, Түдэвтэй, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Шилүүстэй сумд 2024 онд нийт 562.4 сая төгрөгийн урамшуулал авч ОНХС-ийн орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлсэн байна. Бусад сумд ОНХС-ийн үйл ажиллагаагаа сайжруулж, гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллаар ОНХС-ийн орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Аймгийн ОНХС-аас сумдад олгох орлогын шилжүүлгийг аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/478 дугаар захирамжаар, сумдад олгох орлогын шилжүүлгийн хуваарийг баталжээ.

Хүснэгт-1 Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлэг /сая төгрөг/

№	Сумын нэр	Орлогын шилжүүлэг	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	Тогтвортой амьжиргаа-3 төсөл” урамшуулал	ОНХС-ийн нийт эх үүсвэр
1	Алдархаан	319.6	-	-	-	319.6
2	Асгат	112.0	7.7	-	-	119.6
3	Баянтэс	379.3	-	-	41.6	420.9
4	Баянхайрхан	235.1	1.5	-	32.8	269.3
5	Дөрвөлжин	342.7	8.6	70.2	-	421.4
6	Завханмандал	202.3	9.6	10.9	-	222.8
7	Идэр	230.3	-	-	30.7	261.0
8	Их-Уул	699.3	-	-	71.3	770.5
9	Нөмрөг	250.0	-	-	23.9	273.8
10	Отгон	321.1	-	-	35.9	357.1
11	Сантмаргаз	216.8	11.9	0.8	-	229.5
12	Сонгино	203.3	3.2	0.0	22.9	229.4
13	Тосонцэнгэл	954.2	-	8.6	93.2	1,056.0
14	Тэс	335.0	-	-	-	335.0

15	Тэлмэн	272.5	-	-	43.5	316.0
16	Түдэвтэй	271.9	-	-	24.4	296.3
17	Улиастай	632.9	-	-	85.2	718.1
18	Ургамал	205.6	18.5	10.3	-	234.4
19	Цагаанхайрхан	134.4	-	-	17.2	151.6
20	Цагаанчулуут	140.8	-	-	18.7	159.5
21	Цэцэн-Уул	206.7	-	-	23.3	230.0
22	Шилүүстэй	186.8	2.4	-	20.7	209.9
23	Эрдэнэхайрхан	214.0	-	15.0	-	229.1
24	Яруу	228.2	-	-	30.1	258.4
Дүн		7,294.8	63.2	115.9	615.3	8,089.2

1.1.4 ОНХС-ийн хөрөнгийн бусад орлогын эх үүсвэрийн 75.4 хувийг бүрдүүлж, зарцуулсан байна.

Сумдын орон нутгийн хөгжлийн санд нийт 6.061.6 сая төгрөгийг бусад эх үүсвэрээс бүрдүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр 4,568.2 сая төгрөгийг бүрдүүлж, зарцуулсан байна.

Бусад эх үүсвэрээр бүрдүүлсэн орлогыг төрөл тус бүрээр нь авч үзвэл:

Хүснэгт-2 Орон нутгийн хөгжлийн санд төвлөрч буй бусад орлого /сая төгрөг/

№	Сумын нэр	ИТХ-ын тогтоолоор баталсан ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл		ТТХ-ийн 60.2.4 "Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон эх үүсвэр"		Өвс тэжээлийн орлого, бусад орлого		Малын тоо толгойн албан татвар		Нийт дүн /гүйцэтгэлээр/
		төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	
1	Алдархаан	177.6	-	-	-	-	0.3	62.7	62.7	63.0
2	Асгат	87.2	-	-	-	-	0.3	9.0	0.0	0.3
3	Баянхайрхан	73.2	-	-	-	-	4.4	22.6	0.0	4.4
4	Баянтэс	6.8	-	-	-	-	0.2	50.0	23.3	23.5
5	Завханмандал	161.6	83.0	-	-	-	1.4	40.0	28.0	112.3
6	Дөрвөлжин	883.3	873.8	-	-	-	2.0	19.7	29.2	904.9
7	Идэр	23.9	-	-	-	-	-	58.3	38.3	38.3
8	Их-Уул	46.1	13.9	-	-	-	0.7	32.4	32.2	46.8
9	Нөмрөг	60.7	-	-	-	-	0.2	17.7	10.0	10.2
10	Отгон	188.5	-	-	-	-	8.0	40.0	40.0	48.0
11	Сантмаргаз	74.3	-	-	-	-	13.3	17.0	0.0	13.3
12	Сонгино	49.8	-	5.0	5.0	-	-	7.0	4.0	9.0
13	Тосонцэнгэл	565.6	432.6	-	-	-	96.9	64.0	64.0	593.5
14	Тэс	50.0	-	-	-	-	0.1	18.0	16.3	16.4
15	Тэлмэн	146.7	102.5	-	-	-	-	33.1	17.4	119.9
16	Түдэвтэй	81.7	-	-	-	-	0.4	41.4	35.0	35.4
17	Ургамал	40.6	40.6	-	-	-	1.6	76.3	59.2	101.5
18	Улиастай	1,894.6	1,876.3	-	-	-	1.2	15.0	18.7	1,896.2
19	Цагаанхайрхан	117.1	11.2	-	-	-	5.4	14.0	14.0	30.6
20	Цагаанчулуут	47.8	-	-	-	-	8.0	12.0	10.5	18.5
21	Цэцэн-Уул	211.7	-	-	-	-	0.5	15.3	4.4	4.9
22	Шилүүстэй	107.2	-	-	-	-	0.1	14.0	17.4	17.6
23	Эрдэнэхайрхан	233.7	-	-	-	-	0.2	1.2	4.1	4.3
24	Яруу	27.4	-	-	-	-	-	18.6	18.6	18.6
25	Аймгийн ОНХС	-	-	-	-	-	436.8	0.0	0.0	436.8
Нийт дүн		5,357.1	3,433.9	5.0	5.0	-	582.0	699.5	547.3	4,568.2

Мөн зарим сумд ОНХС-ийн хөрөнгөөс нөөц бүрдүүлж худалдан авсан өвс, тэжээлийн орлогыг санд төвлөрүүлэхээр төлөвлөөгүй, буцааж төвлөрүүлээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

ОНХС-ийн хөрөнгөөс нөөц бүрдүүлж худалдан авсан өвс, тэжээлийн орлогыг санд буцаан төвлөрүүлээгүй 8.2 сая төгрөгийн зөрчилд Алдархаан, Завханмандал сумдын Засаг дарга нарт албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

1.2 Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хуульд заасан шаардлага, шалгуур хангаагүй зарим төсөл арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

1.2.1. Шат, шатны төсвийн захирагчид ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг авч эрэмбэлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд иргэд, олон нийтийн оролцоог хангах талаар Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйл, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу сумын Засаг дарга нар захирамж гаргаж төсөл арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг байгуулж, иргэдээс ирүүлсэн саналыг шат, шатны ИТХ-д баталсан байна.

Харин Баянхайрхан, Ургамал сумд иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг баталсан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд 5,925.9 сая төгрөгийн 40 төсөл арга хэмжээг төлөвлөж батлахдаа иргэдээс санал авч эрэмбэлээгүй зөрчилд “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт үр дүн” сэдэвт нийцлийн аудитаар албан шаардлага өгсөн бөгөөд хэрэгжилтийн хугацаа байна.

1.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг “Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, аймаг, сумдын Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, аймаг, сумдын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн байна.

Хүснэгт-3 Батлагдсан төсөл арга хэмжээ /сая төгрөг/

№	Сумын нэр	Төсөл арга хэмжээний	
		Тоо	Мөнгөн дүн /сая.төг/
1	Алдархаан	24	514.9
2	Асгат	14	198.4
3	Баянхайрхан	21	291.3
4	Баянтэс	17	361.8
5	Завханмандал	29	544.9
6	Дөрвөлжин	58	2,404.0
7	Идэр	15	362.0
8	Их-Уул	24	605.6
9	Нөмрөг	13	319.3
10	Отгон	38	596.1
11	Сантмаргаз	17	311.8
12	Сонгино	19	368.0
13	Тосонцэнгэл	47	1,433.0

14	Тэс	34	330.3
15	Тэлмэн	43	463.5
16	Түдэвтэй	24	352.8
17	Ургамал	35	376.1
18	Улиастай	113	2,707.0
19	Цагаанхайрхан	22	300.2
20	Цагаанчулуут	19	224.1
21	Цэцэн-Уул	28	413.7
22	Шилүүстэй	17	318.0
23	Эрдэнэхайрхан	15	739.4
24	Яруу	13	300.5
Сумын дүн		699	14,836.3
25	Аймгийн ОНХС	40	5,925.9
Нийт дүн		739	20,762.3

1.2.3 Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хуульд заасан шаардлага, шалгуур хангаагүй, ТЭЗҮ, төсвийн тооцоолол, төсөвт нөлөөлөх байдлын үнэлгээ, газрын зөвшөөрөл зэргийг шийдээгүй зарим төсөл арга хэмжээг төлөвлөж баталсан байна.

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд 20,762.2 сая төгрөгийн 739 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, сумын ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн саналаар дэмжигдээгүй ажлыг жагсаалтад оруулж, санхүүжүүлсэн, ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдаагүй 497.3 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг ИТХ-аар баталсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, 60 дугаар зүйлийн 60.3.6, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь заалтыг зөрчсөн байна.

- Баянхайрхан сумын 136.0 сая төгрөгийн 12 төсөл арга хэмжээ, Ургамал сумын 316.3 сая төгрөгийн 27 төсөл арга хэмжээг иргэдийн саналаар дэмжигдээгүй ажлыг жагсаалтад оруулж, санхүүжүүлэхээр баталсан байна.
- Яруу сумын ИТХ нь “Хүндэтгэлийн гэр өргөө” төсөл арга хэмжээг зураг төсөвгүй, газрын зөвшөөрөл шийдэгдээгүй байхад 45.0 сая төгрөгөөр баталсан;

Төсвийн тухай хуульд заасан шаардлага, шалгуурыг баримтлаагүй ТЭЗҮ хийгдээгүй, шаардагдах хөрөнгө, төсөвт өртгийг тооцоогүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн нь ОНХС-ийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.

Аудитын илрүүлэлт:

Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээ төлөвлөж, санхүүжүүлсэн 497.3 сая төгрөгийн зөрчилд Баянхайрхан, Ургамал сумдын Засаг дарга нарт албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

1.2.4 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй 389.3 сая төгрөгийн 27 төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ОНХС: Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 94 дүгээр тогтоолоор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд нийт 5,265.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 43 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр анх баталж, аймгийн ИТХ-ын 2024 оны 10 дугаар сарын 22-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор 40 төсөл арга хэмжээг 5,925.9 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр тодотгож, гүйцэтгэлээр 47 төсөл арга хэмжээнд 6,817.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 4. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний журмын 4.2-д заасан чиг үүрэг

№	Шалгуур үзүүлэлт	Төсөл арга хэмжээний тоо	Мөнгөн дүн
1	Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологи	17	2,755.9
2	Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ	2	15.0
3	Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах	4	909.2
4	Ундны усан хангамж, эрүүл ахуйг сайжруулах	1	140.0
5	Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн техник эдийн засгийн үндэслэл (цаашид ТЭЗҮ гэх), зураг төсөв боловсруулах	2	186.2
6	Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх	4	1,411.0
7	Өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт	2	315.5
8	Ажлын байр бий болгох		-
9	Журам заасан чиг үүрэгт хамааралгүй	15	1,084.5
Ний дүн		47	6,817.4

Аймгийн ОНХС хөрөнгөөр журмын чиг үүрэгт хамаарахгүй 1,084.5 сая төгрөгийн 15 төсөл, арга хэмжээг төлөвлөж, санхүүжүүлсэн байна. Аймгийн ОНХС-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар журам зөрчсөн төсөл арга хэмжээ төлөвлөж, санхүүжүүлсэн 942.1 сая төгрөгийн, төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл арга хэмжээ болон төсөвт өртгөөс илүү санхүүжүүлсэн 610.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, хэрэгжилтийн хугацаа болоогүй байна. Аудитаар 142.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Сумдын ОНХС: Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд нийт 14,836.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 699 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шалгахад ОНХС-ийн чиг үүрэгт хамаарахгүй, журам зөрчсөн дараах төсөл, арга хэмжээг төлөвлөж, санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Алдархаан сум нь Өгөөмөр, Мандат багт хадлангийн талбайг хамгаалахад 14.0 сая төгрөг зарцуулсан;
- Баянтэс сум нь 8.0 сая төгрөгөөр гэр худалдан авч 2 иргэнд хандиваар өгсөн;
- Дөрвөлжин сум нь “Нээлтэд бүжиглэх 100 бүжигчинд бүжгийн хувцас гутал авах, 100-н жилийн ойд зориулж ном бүтээх, хэвлэх, Төрийн үйлчилгээ багт-2024 арга хэмжээг зохион байгуулах, 100 жилийн ойд зориулж нутгийн золгуут зохион байгуулах, Баяр наадмын урилга хэвлүүлэх, Сумын 100 жилийн ойг угтсан бэлтгэл ажилд Сурын холбоо /асар майхан/, Сумын 100 жилийн ойг угтсан бэлтгэл ажилд Бөхийн холбоо, Шагайн холбоо, Уяачдын холбоо, Сумын танилцуулга видео шторк хийлгэж нийт 164.1 сая төгрөг зарцуулсан;
- Улиастай сум нь Хөгжим бүжгийн коллежид дэмжлэг, УИХ-ын самбар, геодезийн цэг тэмдгийн тооллого явуулах, Улс, аймаг, сумын аварга малчин, тэргүүний тариаланч, фермер шалгаруулж, хүндэтгэл үзүүлэх, ургацын баяр зохион байгуулах зэрэг нийт 44.0 сая төгрөгийг зарцуулсан;

- Тосонцэнгэл сум нь сумын малчдын чуулга уулзалтыг зохион байгуулахад 13.0 сая төгрөгийг зарцуулсан;
- Цагаанчулуут сум нь 3.8 сая төгрөгөөр хээлтүүлэгч мал худалдан авч, малчдад сугалаа зохион байгуулж тараасан;

Сумдын ОНХС-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар журам зөрчсөн төсөл арга хэмжээ төлөвлөж, санхүүжүүлсэн 781.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, хэрэгжилтийн хугацаа болоогүй байна. Аудитаар 246.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Баянхайрхан сум нь Соёлын төвийн тайзны шинэчлэлийн ажлын санхүүжилтийг 5.0 сая төгрөгөөр илүү олгосон байна.

Аудитын илрүүлэлт:

ОНХС-ийн чиг үүрэгт хамаарахгүй, журам зөрчсөн төсөл, арга хэмжээг, төлөвлөж санхүүжүүлсэн 389.3 сая төгрөгийн, төсөвт өртгөөс илүү санхүүжүүлсэн 5.0 сая төгрөгийн зөрчилд холбогдох албан тушаалтанд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.


БҮЛЭГ 2. ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙГ УРСГАЛ ЗАРДЛЫН ШИНЖТЭЙ, НЭГ УДААГИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛД ХЭТ ИХЭЭР ТӨЛӨВЛӨЖ, ЗАРЦУУЛЖ БАЙГАА НЬ ТУС САНГИЙН ХӨРӨНГИЙН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨГ БУУРУУЛЖ, МӨН ЧАНАРЫГ АЛДАГДУУЛЖ БАЙНА.

2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний 55.6 хувьд шууд худалдан авалт хийсэн нь сангийн хөрөнгийг хэт жижиглэж, журамд нийцээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж санхүүжүүлсэн холбоотой байна.

2.1.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний 55.6 хувьд шууд худалдан авалт хийсэн байна.

Аймгийн хэмжээнд 2024 онд нийт 18,735.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 606 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ТБОНОХБАУХАТХ-ийн дагуу зохион байгуулсан байна.

График №5 Тендер, ХАА зохион байгуулалт



- 18.7 хувь буюу 3,506.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 19 ТАХ-г нээлттэй тендер шалгаруулалтаар;

- 25.4 хувь буюу 4,743.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 75 ТАХ-г харьцуулалтын аргаар;

- 0.3 хувь буюу 61.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 16 ТАХ-г олон нийтийн оролцоотой худалдан авалтаар;

- 55.6 хувь буюу 10,424.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 503 төсөл, арга хэмжээнд шууд худалдан авалт хийсэн.

Дөрвөлжин сум нь ТБОНАХБАУХАТХ-ийн 31.1.1-31.1.3 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг зөрчиж, Засаг даргын Тамгын газрын гадна өнгө засвар, цахилгааны засварыг 22.9 сая төгрөгөөр шууд гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Худалдан авах ажиллагааны журам зөрчсөн Дөрвөлжин сумын Засаг даргад албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

2.1.2 Аймгийн хэмжээнд 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр нийт 739 төсөл арга хэмжээнд 20,762.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс 80.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 9.8 хувь нь дутуу, 8.4 хувь нь огт хэрэгжээгүй байна.

ОНХС-ийн харилцах дансны эхний үлдэгдэл 2,751.0 сая төгрөг, тайлант онд нийт 18,663.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 18,735.9 сая төгрөгийг зарцуулснаар эцсийн үлдэгдэл 2,678.6 сая төгрөг болсон байна. ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд 739 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр 20,762.3 сая төгрөгийг баталснаас 16,711.1 сая төгрөгийн 575 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 2,024.9 сая төгрөгийн 27 төсөл арга хэмжээ дутуу хэрэгжиж, 1,744.7 сая төгрөгийн 134 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

Хүснэгт-5 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл /сая төгрөг/

№	Сумдын нэр	ИТХ-аар батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээ		Бүрэн хэрэгжсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээ		Дутуу хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ		Огт хэрэгжээгүй ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Алдархаан сум	24	514.9	13	249.5	3	103.0	8	111.46
2	Асгат сум	14	198.4	10	175.2			4	23.08
3	Баянхайрхан сум	21	291.3	12	191.5			9	99.75
4	Баянтэс сум	17	361.8	15	296.3			2	61.00
5	Завханмандал сум	29	544.9	27	444.0			2	93.50
6	Дөрвөлжин сум	58	2,404.0	45	1,719.5	5	342.1	0	0
7	Идэр сум	15	362.0	13	323.4			2	35.77
8	Их-Уул сум	24	605.6	20	124.5	1	411.8	4	23.20
9	Нөмрөг сум	13	319.3	8	131.7	1	9.0	4	167.86
10	Отгон сум	38	596.1	30	410.2	2	22.0	6	77.20
11	Сантмаргаз сум	17	311.8	14	255.1	1	28.6	2	17.00
12	Сонгино сум	19	368.0	14	284.6	1	36.7	4	26.65
13	Тосонцэнгэл сум	47	1,433.0	38	1,071.8	1	137.2	8	236.67
14	Тэс сум	34	330.3	21	183.2	1	10.5	12	90.34
15	Тэлмэн сум	43	463.5	36	405.0			7	29.65
16	Түдэвтэй сум	24	352.8	21	231.7	1	35.0	2	30.8
17	Ургамал сум	35	376.1	26	209.9	1	111.3	8	29.5
18	Улиастай сум	113	2,707.0	86	2,243.3			27	236.59
19	Цагаанхайрхан	22	300.2	19	264.6			3	30.70
20	Цагаанчулуут сум	19	224.1	15	140.0	1	18.0	3	32.20
21	Цэцэн-Уул сум	28	413.7	17	225.5	1	44.2	10	129.38
22	Шилүүстэй сум	17	318.0	11	281.1			6	42.74
23	Эрдэнэхайрхан сум	15	739.4	9	250.1	3	211.7	3	116.39
24	Яруу сум	13	300.5	12	285.9			1	3.26
Сумын дүн		699	14,836.3	532	10,397.5	23	1,521.0	137	1,744.7
25	Аймгийн ОНХС	40	5,925.9	43	6,313.5	4	503.9	-	-
Нийт дүн		739	20,762.3	575	16,711.1	27	2,024.9	137	1,744.7

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэл 80.5 хувьтай байгаа нь төлөвлөлт бодитой хийгдээгүй, улирлын чанартай ажлыг

бүрэн хэрэгжих боломжгүй хугацаанд гэрээ байгуулсан, санхүүжилт оройтсон зэрэгтэй холбоотой байна.

ОНХС-ийн гүйцэтгэлийг аймаг, сумдаар авч үзвэл:

График-2



График-3



ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг ТЭЗҮ хийгдээгүйгээс төсөвт өртгийг зах зээлийн үнээс бага төлөвлөсөн, санхүүжилт оройтсон, эрт хүйтэрсэн гэх шалтгаанаар дараах ажлууд гэрээний хугацаанд хэрэгжээгүй, бүрэн дуусаагүй байна. Үүнд:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 24 сумын ерөнхий боловсролын сургуулиудад "Итгэлтэй утас" байрлуулах 19.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг "Алдар жагал" ХХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, санхүүжилтийг олгосон боловч ажил бүрэн хийгдээгүй;
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Тэс сумын төвд соёл амралтын хүрээлэн байгуулах 199.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг "Чандмань хонгор групп" ХХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, 194.0 сая төгрөгийг олгосон боловч ажил бүрэн хийгдээгүй;
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Тосонцэнгэл суманд "ENSURE" төсөлтэй хамтарч дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулах ажлын гүйцэтгээгч шалгараагүй байхад 150.0 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан;
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Тосонцэнгэл суманд Ус цэвэршүүлэх иж бүрэн төхөөрөмж суурилуулах 140.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг Тосонцэнгэл сумын ЗДТГ-т эрх шилжүүлж, 140.0 сая төгрөгийг олгосон боловч ажил бүрэн дуусаагүй, хүлээж аваагүй;
- Их-Уул сумын ОНХС-ийн хөрөнгөөр "Ахуйн үйлчилгээний барилга барих" 450.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг "Яруу жаргалант" ХХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, 411.8 сая төгрөгийн урьдчилгаа олгосон боловч ажил бүрэн хийгдээгүй;
- Нөмрөг сумын ОНХС-ийн хөрөнгөөр Зам дагуу модны хайс хамгаалалт хийх 14.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг Иргэн Т.Гантуяагаар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, 9.0 сая төгрөгийн урьдчилгаа олгосон боловч ажил бүрэн хийгдээгүй;
- Отгон сумын ОНХС-ийн хөрөнгөөр Соёлын төвийн дотор халаалтад холбох 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг иргэн Б.Мөнхжаргалаар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, 6.0 сая төгрөгийн урьдчилгаа олгосон боловч ажил бүрэн хийгдээгүй;
- Сонгино сумын ОНХС-ийн хөрөнгөөр Спорт заалны резинэн шал солих засварын 56.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг "Од дизайн" ХХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, 36.7 сая төгрөгийн урьдчилгаа олгосон боловч ажил бүрэн хийгдээгүй;

- Тосонцэнгэл сумын ОНХС-ийн хөрөнгөөр Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр хийлгэх 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “Циркулпроект” ХХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, 137.2 сая төгрөгийн урьдчилгаа олгосон боловч ажил бүрэн хийгдээгүй,
- Цагаанчулуут сумын ОНХС-ийн хөрөнгөөр Соёл амралтын талбай барих 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “Г.Мөнх-Учрал ахлагчтай иргэдийн бүлэг”-ээр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, 18.0 сая төгрөгийн урьдчилгаа олгосон боловч ажил бүрэн хийгдээгүй,
- Цэцэн-Уул сумын ОНХС-ийн хөрөнгөөр Худаг шинээр гаргах 52.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “Люминус вэйе” ХХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, 44.2 сая төгрөгийн урьдчилгаа олгосон боловч ажил бүрэн хийгдээгүй,

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх улирлын чанартай ажлыг бүрэн хэрэгжих боломжгүй хугацаанд гэрээ байгуулдаг, гэрээ байгуулмагц санхүүжилтийг бүрэн олгодог, бодит гүйцэтгэлд үндэслэж санхүүжилтийг олгодоггүй зөрчил нийтлэг байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.5, 3.4.3, 8.5 дахь заалтыг зөрчиж байна.

Сумдын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар гэрээний хугацаанд хэрэгжээгүй, бүрэн дуусаагүй 858.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн бөгөөд хэрэгжилтийн хугацаа болоогүй байна.

ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих шат шатны хяналтыг сайжруулж, гүйцэтгэлийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай байна.

Аудитын илрүүлэлт:

Гэрээний хугацаанд хэрэгжээгүй, бүрэн дуусаагүй 1,166.7 сая төгрөгийн зөрчилд холбогдох албан тушаалтанд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

2.2 ОНХС-ийн хөрөнгийг урсгал зардлын шинжтэй, нэг удаагийн арга хэмжээний зардалд хэт ихээр төлөвлөж, зарцуулж байгаа нь тус сангийн хөрөнгийн үр нөлөөг бууруулж, мөн чанарыг алдагдуулж байна.

2.2.1 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнээс гарах үр дүн, үр нөлөөг урьдчилж тооцохгүй байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2, 4.4-д “... ОНХС-ийн хөрөнгөөр барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх ажлыг санхүүжүүлнэ” гэж заасан бөгөөд ОНХС-ийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлэхээр зохицуулагдсан байдаг.

Аймаг, сумд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үр өгөөжийг тооцоогүй, зорилтот түвшин, үр ашиг, үр дүнг бодитоор тодорхойлоогүй байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй ажлуудын зорилго, зорилт, хүрэх түвшнийг тооцохгүй байгаагаас үр нөлөө буурч байна.



Ургамал сум 160.0 сая төгрөгөөр бүх нийтийн биеийн тамирын спортын талбай байгуулахаар “Их хордол групп” ХХК-тай гэрээ байгуулан, 111.3 сая төгрөгийн урьдчилгаа олгож, гүйцэтгүүлсэн боловч хүлээж аваагүй, тус ажил чанаргүй хийгдэж дээвэр нь шуурга салхинд эвдэрсэн байна. Ургамал сумын ОНХС-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан

шаардлага өгсөн бөгөөд хэрэгжилтийн хугацаа болоогүй байна.

2.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр өгөхүйц төсөл арга хэмжээ цөөн хэрэгжсэн байна.

Завхан аймгийн хэмжээнд 2024 онд аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 606 төсөл арга хэмжээнд 18,735.9 сая төгрөгийг зарцуулснаас 33 хувь буюу 6,190.6 сая төгрөг нь үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмж бэлтгэхэд, 10.6 хувь буюу 1,982.4 сая төгрөг нь иргэдэд амьдрах таатай орчин бүрдүүлэхэд, 52.9 хувь буюу 9,918.5 сая төгрөг нь урсгал зардлын шинжтэй нэг удаагийн арга хэмжээний зардалд зарцуулжээ.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгийг ус цэвэршүүлэх төхөөрөмж, ЕБС, цэцэрлэгийн их засвар, ойн нөхөн сэргээлт хийх зэрэг олон нийтэд чиглэсэн, нийтийн эрх ашигт нийцсэн төсөл, арга хэмжээнд зарцуулж байгаа боловч “Чадварлаг эмч”, “Чадварлаг багш”, “Нээлттэй-Завхан” хөтөлбөрийн хүрээнд арга хэмжээ зохион байгуулах, аймгийн Засаг даргын дэргэдэх “Өсвөрийн шигшээ баг”-ийг 10 төрлөөр байгуулж спорт холбоо, сонирхлын бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжих, Кибер аюулгүй байдлын хяналтыг сайжруулах, гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх, Улс, аймгийн аварга малчин шалгаруулж хүндэтгэл үзүүлэх, Тэгш ой тохиож буй сумдад дэмжлэг үзүүлэх, Орон нутагт зохион байгуулж буй онцлог үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд сурталчлах, гадаадын улс орнуудтай хамтран олон талт арга хэмжээг зохион байгуулах, гэрээ санамж бичиг байгуулах, Завхан аймаг “Тыва” Улс хоорондын хамтын ажиллагааны хүрээнд “Кызыл” хотод арга хэмжээ зохион байгуулах, Аялал жуулчлалын түнш аймгийн хүрээнд Монголын аялал жуулчлалын холбоотой хамтарч аялал жуулчлалын цогц арга хэмжээ хэрэгжүүлэх зэрэг урсгал зардлын шинжтэй, нэг удаагийн арга хэмжээний зардалд хэт ихээр төлөвлөж, зарцуулсан байна. Иймд аймгийн засаг даргад зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд аймаг, сумд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний сайн жишээ:

Идэр сум:

- Идэр сум 213.7 сая төгрөгөөр Нийтийн халуун ус шинээр барьж ашиглалтад оруулжээ. Дотроо халуун усны 3 дүүш, 2 том угаалгын машинтай угаалгын өрөө 1, фитнесийн танхим 1, нойлын өрөө 1 бүгд хэвийн ажиллаж байна. Халуун ус ашиглалтад орсноор шинээр 2 ажлын байр бий болж орлогоороо цалинжин ажиллаж байна. Хөрөнгө оруулалтын ажил чанарын өндөр түвшинд сайн хийгдсэн гэж ажлын хэсэг дүгнэн сумуудад байхгүй жишиг халуун ус болсон гэж аймгийн удирдлагууд дүгнэсэн байна.

Тэс сум:

- Тэс сум 10.0 сая төгрөгөөр ЕБС-ийн хүүхдийн шүдний үзлэг шинжилгээнд бүх ангийн сурагчдыг бүрэн хамруулж, дараалан 3 жил үе шаттай зохион байгуулснаар сурагчдын шүдний өвчлөл эрс буурсан байна. Зарим сурагчид нүүр ам шүдний аливаа өвчлөлийг эрт шатанд мэдсэнээр эмчлэгдэх бүрэн нөхцөл боломж үүссэн зэрэг олон давуу талтай ажил болжээ.

Тэлмэн сум:

- Тэлмэн сум 60.0 сая төгрөгөөр ЭМТ-ийн эхо аппарат худалдан авснаар сумын ард иргэдэд цаг хугацаа алдалгүй эрүүл мэндийн үзлэг үйлчилгээг үзүүлж, аливаа өвчлөлийг эрт шатанд илрүүлснээр эмчлэгдэх бүрэн нөхцөл боломж үүссэн зэрэг олон давуу талтай ажил болсон байна.

Завханмандал сум:

- Завханмандал сум 6.5 сая төгрөгөөр Нийтийн эзэмшлийн гудамж хорооллын гэрэлтүүлгийн хийснээр Сумын төвийн гэр хорооллын бүх гудамж 220 квт-ийн гэрэлтүүлэгтэй болж, иргэдэд маш сайн үйл хэрэг болсон бөгөөд хүүхэд, хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжин ажилласан нь иргэдийн талархлыг хүлээжээ.

Цагаанчулуут сум:

- Цагаанчулуут сум 20.6 сая төгрөгөөр Ундны усны эх үүсвэрт цэвэршүүлэгч суурилуулжээ. Ундны усны хатуулгыг бууруулах шүүлтүүр тавьсан нь сумын ард иргэдийн эрүүл мэндэд нэн хэрэгтэй ажил болсон бөгөөд иргэдийн талархлыг хүлээсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Баянхайрхан, Ургамал сумд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг ИТХ-аар батлахдаа хэт жижиглэж, өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй 166.2 сая төгрөгийн зөрчилд Засаг дарга нарт албан хүрүүлэхээр шийдвэрлэлээ.

2.3 ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байна.

2.3.1 Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгүүдийг зориулалтын дагуу ашиглаж байгаа боловч 249.3 сая төгрөгийн хөрөнгө ашиглалтгүй, үр дүнгүй болсон байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгө нь тухайн орон нутгийн иргэд болон эзэмшигч, ашиглагч байгууллагын шаардлагад нийцэж, ашиглалтын байдал хэвийн эсэхийг шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тосонцэнгэл суманд хог шатаах зуухны байрыг 249.3 сая төгрөгөөр барьсан бөгөөд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнээс гарах үр дүн, үр нөлөөг тооцоогүйгээс цахилгааны эх үүсвэргүй газарт барьж, одоог хүртэл ашиглаагүй, үр дүнгүй, ашиглалтгүй хөрөнгө бий болсон байна.



2.3.2 ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт зохистой байна.

Аудитын явцад Алдархаан, Дөрвөлжин, Идэр, Их-Уул, Тосонцэнгэл, Тэлмэн, Ургамал сумдад ажиллаж, ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг шалгахад хэвийн байна.

Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг холбогдох байгууллагуудад эзэмшүүлсэн бөгөөд аудитын нэгдсэн судалгаанаас дүгнэхэд хадгалалт хамгаалалтын байдал зохистой байна гэж үзлээ.

БҮЛЭГ 3. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНД АЙМАГ, СУМДЫН ИТХ, ЗДТГ ХЯНАЛТ ТАВЬЖ, ТАЙЛАГНАХ ҮҮРГЭЭ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 39.6 хувьд сумдын ИТХ хяналт хэрэгжүүлээгүй байна.

3.1.1 Аймаг, сумын ИТХ болон СХДАА-аас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.

Завхан аймгийн 24 сумын ИТХ-ын хяналтын хорооноос 2024 онд хэрэгжүүлсэн нийт 559 төсөл, арга хэмжээний 60.4 хувь буюу 338 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьсан байна.

Баянхайрхан, Дөрвөлжин, Ургамал, Улиастай, Цэцэн-Уул, Шилүүстэй, Эрдэнэхайрхан, Яруу сумдын ИТХ-ын хяналтын хороо ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд 2024 онд хяналт тавьж ажиллаагүй байна.

Завхан аймаг дахь Төрийн аудитын газраас 2024 онд Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг сумдын Засаг дарга нарт хүргүүлж, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар чиглэл өгсөн боловч хэрэгжилт хангалтгүй дээрх нэр бүхий сумдын Засаг дарга нарт албан шаардлагыг хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Аймгийн Засаг дарга нь аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн болон аймгийн ИТХ-ын хяналтын хорооноос хяналтыг тус тус хэрэгжүүлсэн байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.4 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 559 төсөл, арга хэмжээнд хяналт огт хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймаг болон сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнд хяналтыг хэрэгжүүлээгүй тул хяналтыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Уламжлах асуудал: Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд аймаг, сумын ИТХ, СХДАА-аас хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүйд тооцох хариуцлагын талаар заалт байхгүйгээс жил бүр аудитаар илрэх зөрчлийн тоо буурахгүй байгаа тул тус асуудлыг ҮАГ-аар дамжуулан Сангийн яаманд хүргүүлж байна.

3.1.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлд холбогдох мэргэжлийн байгууллагуудыг оролцуулан захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Аудитын нэгтгэл судалгаагаар аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр бүрэн хэрэгжсэн 16,711.1 сая төгрөгийн 575 төсөл арга хэмжээнээс 48.7 хувь буюу 280

төсөл, арга хэмжээнд, дутуу хэрэгжсэн 27 төсөл, арга хэмжээнээс 635.1 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт №6 Захиалагчийн хяналтын судалгаа

№	Аймаг, сумын нэр	ГХБХБГ	ХБТХОХ	Засаг дарга	Нийт
1	Завхан аймаг	2	45		47
2	Алдархаан			10	10
3	Баянхайрхан			5	5
4	Баянтэс			15	15
5	Идэр			13	13
6	Их-Уул			21	21
7	Нөмрөг			9	9
8	Отгон			32	32
9	Сонгино			15	15
10	Тэлмэн			34	34
11	Тэс			23	23
12	Түдэвтэй			21	21
13	Ургамал			24	24
14	Улиастай	9			9
15	Цагаанхайрхан			19	19
16	Цагаанчулуут			16	16
Нийт дүн		11	45	257	313

ОНХС-ийн өмнөх оны гүйцэтгэлийн аудитаар 93 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн бол тайлант онд 280 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хууль, журмын дагуу хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажилласан байна.

Улиастай сумын Засаг дарга нь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай барилга угсралт, их засварын ажилд захиалагчийн хяналт хийхээр 15 төсөл, арга хэмжээний 1,397.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, зарим ажлын худалдан авах ажиллагаа зарлагдаагүй хүлээгдэж байгаа ажлууд болон гүйцэтгэгч шалгараагүй байгаа ажлуудын захиалагчийн албаны зардал тодорхой болсны дараа хавсралт шинэчлэхээр гэрээ байгуулсан хэдий ч гэрээгээ дахин шинэчилж, хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

3.1.3. Өмнөх оны гүйцэтгэлийн аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт 92.3 хувьтай байгаа ч зарим сумд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аймаг дахь Төрийн аудитын газраас 2024 онд гүйцэтгэсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт зарцуулалт, үр дүн үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар нийт 8,712.9 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 6.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,278.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 44.0 сая төгрөгийн зөрчлийг хууль, хяналтын байгууллагад шилжүүлж, 7,384.0 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 155 заалт зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд өгсөн бөгөөд шийдвэрийн хэрэгжилт 92.3 хувьтай байна.

Алдархаан, Асгат, Баянхайрхан, Ургамал сумдын ОНХС-д өмнөх аудитаар өгсөн нийт 563.1 сая төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй байна.

Төсөв захирагчид өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээг хэт жижиглэж аудитаар илэрсэн зөрчил давтагдан гарсан, ажлыг чанаргүй, үр дүнгүй дутуу хийсэн,

гэрээний хугацаанд ажлыг хүлээлгэн өгөөгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон, дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй зэрэг зөрчлүүд давтан гарсаар байна.

Аудитын илрүүлэлт:

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй Алдархаан, Асгат, Баянхайрхан, Ургамал сумдын Засаг даргад албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

3.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн тайланг, журмын дагуу Сангийн яаманд хүргүүлсэн байна.

3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнасан байна.

Сумд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний 2024 оны хэрэгжилтийн тайланг гаргаж, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.2-д заасны дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.9-д заасны дагуу Сангийн яаманд хүргүүлсэн байна.

3.2.2 ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар бий болсон 147.9 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна” гэж заасан бөгөөд аудитаар ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Асгат сумын 4.5 сая төгрөгийн “Завхан аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан”-ийн систем, Баянхайрхан сумын сургуульд 10.0 сая төгрөгийн сурагч ширээ сандал, Тосонцэнгэл суманд сургуульд 9.1 сая төгрөгийн бөхийн дэвжээ, 99.8 сая төгрөгийн Улаантолгой багт явган хүний зам, 19.0 сая төгрөгийн Сум дундын Цагдаагийн хэлтэст тоног төхөөрөмж, 5.5 сая төгрөгийн Онцгой байдлын газрын 173 дугаар салбар Тосонцэнгэл сум дахь Онцгой байдлын хэлтэст гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж зэрэг 147.9 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна.

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон 147.9 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7-д “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасныг зөрчиж, хөрөнгө эзэнгүйдэх, үрэгдэх эрсдэлийг үүсгэж байна.

Аудитын илрүүлэлт:

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон

147.9 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй зөрчилд холбогдох албан тушаалтанд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

3.2.3 Зарим сумд “Удирдлагын мэдээллийн систем”-д ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг дутуу мэдээлж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аймгийн ОНХС болон 19 сумд ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг “Удирдлагын мэдээллийн систем”-д бүрэн оруулсан байна. Харин Тосонцэнгэл, Ургамал, Эрдэнэхайрхан, Яруу сумд ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг “Удирдлагын мэдээллийн систем”-д дутуу оруулсан байна.

Баянхайрхан сум ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 21 төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг “Удирдлагын мэдээллийн систем”-д огт мэдээлээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг “Удирдлагын мэдээллийн систем”-д дутуу болон огт мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй Баянхайрхан, Тосонцэнгэл, Ургамал, Эрдэнэхайрхан, Яруу сумдын Засаг дарга нарт албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

3.2.4 ОНХС-гийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, тендер сонгон шалгаруулалтын талаарх мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тухай бүр оруулсан байна.

ОНХС-ийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тухай бүр оруулж, ил тод мэдээлсэн байна.

АУДИТААР НИЙТ 2,652.9 САЯ ТӨГРӨГИЙН ЗӨРЧИЛ ИЛРҮҮЛЖ, 46 АЛБАН ШААРДЛАГА, ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТТЭЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧИЛД 46 ЗААЛТ ЗӨВЛӨМЖИЙГ ХОЛБОГДОХ АЛБАН ТУШААЛТАНД ХҮРГҮҮЛЛЭЭ.

---oOo---

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. 2024 онд ОНХС-ийн хөрөнгөөр нийт 739 төсөл арга хэмжээнд 20,762.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс 80.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 9.8 хувь нь дутуу, 8.4 хувь нь огт хэрэгжээгүй байна.
2. ОНХС-ийн төлөвлөлтийн тухайд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулсан байна.
3. ОНХС-ийн хөрөнгийг урсгал зардлын шинжтэй, нэг удаагийн арга хэмжээний зардалд хэт ихээр төлөвлөж, зарцуулж байгаа нь тус сангийн хөрөнгийн үр нөлөөг бууруулж, мөн чанарыг алдагдуулж байна.
4. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр өгөхүйц төсөл арга хэмжээ цөөн хэрэгжүүлжээ. Иймд орон нутагт үр өгөөжтэй, томоохон хөрөнгө оруулалтын ажлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.
5. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй 389.3 сая төгрөгийн 27 төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн бөгөөд 1,166.7 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээ гэрээний хугацаанд хэрэгжээгүй, бүрэн дуусаагүй байна.
6. Алдархаан, Завханмандал сумд ОНХС-ийн хөрөнгөөс нөөц бүрдүүлж худалдан авсан өвс, тэжээлийн 8.2 сая төгрөгийн орлогыг буцаан төвлөрүүлээгүй байна.
7. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгүүдийг зориулалтын дагуу ашиглаж байгаа боловч 249.3 сая төгрөгийн хөрөнгө ашиглалтгүй, үр дүнгүй болжээ.
8. ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 147.9 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.
9. Өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт 92.3 хувьтай байна.
10. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлд холбогдох мэргэжлийн байгууллагуудыг оролцуулан захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.
11. Зарим сумд “Удирдлагын мэдээллийн систем”-д ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг дутуу мэдээлж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Г.ӨНӨРБАЯР-Т

1. ОНХС-ийн хөрөнгийг урсгал зардлын шинжтэй, нэг удаагийн арга хэмжээний зардалд төлөвлөж, зарцуулахгүй байх;
2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр өгөхүйц, иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төлөвлөж зарцуулах;

СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ

1. ОНХС-ийн хөрөнгийг урсгал зардлын шинжтэй, нэг удаагийн арга хэмжээний зардалд төлөвлөж, зарцуулахгүй байх;
2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр өгөхүйц, иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төлөвлөж зарцуулах;
3. Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 20-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;



**ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас: 7575-1155, Факс: 7046-2550
И-мэйл: za@zavkhan.gov.mn

2025.07.01 № 3/668
танай _____ -ны № _____ Т

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

“Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Тайлангийн төсөлтэй холбоотой санал байхгүй байна.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Б.ЧАДРААБАЛ



Doc toot a5

8119090926